



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2025 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 304

Улаанбаатар хот

Нууцын жагсаалт батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 11 дүгээр зүйл, 14 дүгээр зүйлийн 14.1, 20 дугаар зүйлийн 20.4, Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Санхүүгийн зохицуулах хорооны албаны нууцад хамаарах баримт бичиг, мэдээллийн жагсаалт”-ыг нэгдүгээр, “Санхүүгийн зохицуулах хорооны төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан жагсаалтыг нууц баримт бичгийг боловсруулах, хадгалж хамгаалах, ашиглах үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2017 оны 503 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА



Т.ЖАМБААЖАМЦ

1518000689

Санхүүгийн зохицуулах хорооны даргын  
2025 оны 08 дугаар сарын 22-ний өдрийн  
304 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ БАРИМТ БИЧИГ,  
МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Д/Д	Албаны нууцад хамаарах баримт бичиг, мэдээлэл
1	Санхүүгийн зах зээл, хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн зохицуулах хорооны даргын шийдвэрийн төсөл батлагдах хүртэл
2	Албаны нууцад хамаарах мэдээллээр төрийн байгууллага, бусад этгээдтэй харилцсан албан бичиг, мэдээлэл
3	Албаны нууцад хамаарах мэдээлэл хэлэлцсэн хуралдааны тэмдэглэл, шийдвэр, бусад нууц тээгч
4	Зөрчлийн хэрэг бүртгэлт, хяналт шалгалтын явцтай холбоотой баримт бичиг, мэдээлэл, шийдвэр
5	Санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаанд оролцох гэж байгаа болон оролцож байгаа гадаад, дотоодын аж ахуйн нэгж, хувь хүний Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн хөрөнгө, бизнесийн үйл ажиллагаа, техник, тоног төхөөрөмж, технологийн шийдэл, бусад мэдээлэл, баримт бичиг
6	Үнэт цаасны арилжаа болон хэлцэлд оролцож буй талуудын мэдээлэл, үнэт цаасны дансны үлдэгдэл болон дэлгэрэнгүй мэдээлэл, үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн байгууллагууд хоорондын мэдээлэл
7	Албаны нууцад хамаарах мэдээллийг агуулсан дотоод аудитын ажлын тайлан, холбогдох баримт бичиг
8	Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө
9	Албаны нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, бусад тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан, устгасан тухай мэдээ, акт, баримт бичиг
10	Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаарх мэдээ, мэдээлэл
11	Төрийн болон албаны нууц баримт бичгийн бүх төрлийн бүртгэл
12	Санхүүгийн зохицуулах хорооны албан хаагчдын хувийн хэрэг, үнэлгээ, сахилгын шийтгэлийн талаарх мэдээлэл
13	Зохицуулалттай салбарын дэлгэрэнгүй бүртгэлийн нийтэд зориулагдаагүй мэдээлэл, дотоод мэдээлэл

Санхүүгийн зохицуулах хорооны даргын  
2025 оны 11 дугаар сарын 22-ний өдрийн  
30.1 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТӨРИЙН НУУЦТАЙ ТАНИЛЦАХ ЭРХ БҮХИЙ АЛБАН  
ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ

Д/Д	Албан тушаал	Төрийн нууцтай танилцах эрхийн түвшин	
		I түвшин	II түвшин
1	Дарга	+	
2	Орон тооны гишүүн, дэд дарга		+
3	Орон тооны бус гишүүн		+
4	Ажлын албаны дарга		+
5	Нэгжийн дарга		+
6	Ахлах зөвлөх		+
7	Нууц хамгаалах ажилтан	+	
8	Бусад албан хаагч /зөвхөн албан тушаалын чиг үүрэгтэй холбоотой баримт бичигтэй Санхүүгийн зохицуулах хорооны дарга болон Ажлын албаны даргын зөвшөөрлөөр/		+

----- ооо -----